

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
Э.ГАНБОЛДЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ болон хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд хилийн хорио цээрийн хяналтын чиг үүргийг нэмж, холбогдох судалгаа, тайлбар хийж шинэчлэн боловсруулсан байна.	“Ажлын хэсэг байгуулах тухай” ГЕГ-ын даргын 2023 оны №А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрүүдэд орж ажилласан. Энэ хугацаанд 2021-2023 онд шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн. Мөн гаалийн байгууллагын чиг үүрэгт шинээр орсон хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын асуудлыг шинээр бүлэг болгон Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Түүнчлэн гадаад улсуудын жишиг, УИХ-ын гишүүдтэй хийсэн уулзалт дээр өгсөн чиглэлийн дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлд нэгтгэн найруулав. Гаалийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн найруулсан.	01.01-12.08	100

				ДГБ-ын багц стандарт, гарын авлага, бусад орны хууль тогтоомжуудыг судалж, Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенци /Киото контенци/ болон түүнд оруулах өөрчлөлтүүд, ДГБ-аас өгсөн зөвлөмжүүдтэй танилцсан. Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүд, гаалийн газар хороодоос ирсэн саналуудтай нэгбүрчлэн танилцаж, ирсэн саналуудыг бүлэглэн хуулийн төслийн холбогдох хэсгүүдэд тусган, хүлээн авах боломжгүй саналуудын шалтгааныг тэмдэглэн ажиллав. Хуулийн төслийн холбогдох заалтуудыг боловсруулах үед ГЕГ-ын холбогдох бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, гарч буй хүндрэл, хуулиар зохицуулах шаардлагатай байгаа асуудлууд, худалдаа хөнгөвчлөх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын талаар ярилцаж саналуудыг тусган ажилласан болно. I хэсэг.Ерөнхий зүйл Хуулийн зорилго, томъёоны тодорхойлолт хэсэгт буюу I-IV бүлэгт хорио цээрийн хяналт шалгалттай холбоотой асуудлыг нэмж тусгасан. II хэсэг.Мэдээлэл, зөвлөгөө лавлагаа, гомдол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Захиргааны ерөнхий хууль, ДХБ-ын ХХХ-т заасан “Хэвлэл нийтлэл болон мэдээллийн хүртээмж”, “Цахим төлбөр”, “Гомдол гаргах болон гомдлыг хянан шалгах ажиллагаа”, Гаалийн бүрдүүлэлтийн горимыг уялдуулах, хялбарчлах тухай конвенцийн “Мэдээлэл технологи ашиглах”, Статистикийн тухай хууль, Нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлийг хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг судалсан. Мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа, гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах, гаалийн статистик, мэдээллийн технологи ашиглахтай холбогдсон харилцааг Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Мэдээллийн		
--	--	--	--	---	--	--

				технологийн газраас ирүүлсэн санал, холбогдох хууль тогтоомжийн заалтуудтай уялдуулан боловсруулсан. III хэсэг.Гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх, чөлөөлөх Гаалийн тарифын тогтолцоо, гаалийн татвар тогтоох хэлбэр, гаалийн тарифын зөвлөл, гаалийн үнэ, барааны ангилал, импортын барааны гарал үүсэл, урьдчилсан шийдвэр, гаалийн болон бусад татвар ногдуулах, төлөх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг тусгана. урьдчилсан шийдвэр, барааны ангилал, гаалийн үнэлгээний асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд гаалийн болон бусад татварыг төлөх баталгаа, эсхүл татварыг холбогдох дансанд байршуулан барааг олгох болон татвар, тарифтай итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн гаалийн болон бусад татвар төлөх хугацааг уян хатан болгохтой холбогдсон бусад харилцааг нарийвчлан тусгасан. IV хэсэг.Гаалийн хяналт, бүрдүүлэлт Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн II-X бүлэг буюу 28-186 зүйлд гаалийн хяналт, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх, барааг мэдүүлэх, зарим нэр төрлийн барааг хилээр нэвтрүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх онцлог, гаалийн шалгалттай холбоотой үйл ажиллагааг тусгасан. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн хяналт, шалгалттай холбоотой асуудлыг хуулийн төсөлд нэг бүлэг болгон нэмж тусган, хорио цээрийн хяналтын ангилал, хамрагдах бараа, тавигдах нийтлэг шаардлага, хорио цээрийн үзлэг, халдваргүйжүүлэлт, барааг буцаах зэрэг зохицуулалтуудыг ажлын хэсгийн гишүүд болон Хорио цээрийн хэлтэстэй хамтран боловсруулсан.		
--	--	--	--	---	--	--

				Гаалийн мэдүүлэг, түүний төрөл, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх, урьдчилан мэдүүлэх, мэдүүлэх хугацаа, мэдүүлэгчийн эрх, үүрэг, барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримт, гаалийн мэдүүлэгт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хорио цээрийн хяналттай уялдуулан боловсруулсан. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдлийн мэдээлийн сан, эрсдэл тооцох үйл ажиллагааг тодорхой болгож, хорио цээрийн эрсдэлийн удирдагыг гаалийн эрсдэлийн удирдлагатай уялдуулан найруулсан болно. Гаалийн хяналтад орчин үеийн дэвшилтэт техник технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, гаалийн тэмдэглэгээ хийхэд ухаалаг ломбо ашиглах заалт, гаалийн магадлан шинжилгээнд ирүүлэх барааны тоо тэмжээг тогтоох заалт нэмж оруулсан. Гаалийн итгэмжлэгдсэн операторын зохицуулалтыг шинээр оруулсан. Зөвшөөрлийн тухай хуульд Гаалийн түр агуулах ажиллуулах үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан тул хуульд нийцүүлэн нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан. Гаалийн хяналтын бүс тогтоох, сунгах, түдгэлзүүлэх, татан буулгах, Гаалийн тээвэрлэгчээр бүртгэх үйл ажиллагааг цахимд шилжүүлсэнтэй холбоотой тавигдах нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг бусад зөвшөөрөлтэй уялдуулсан. Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалттай холбогдсон харилцааг тодорхой тусгаж, шалгалтын төрөлтэй холбоотой хэсгийг өөрчлөн найруулж, гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтаар гаалийн байгууллагад барааг мэдүүлээгүй, өөр бараагаар, эсхүл дутуу мэдүүлсэн зэрэг зөрчилд шийтгэл ногдуулсан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш барааг		
--	--	--	--	--	--	--

				гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн бүрдүүлэлт хийлгэх, бусад зөрчилд шийтгэлийн хуудсаар шийдвэрлэхээр төсөлд тусгав. V хэсэг.Гаалийн бүрдүүлэлтийн горим Гаалийн тухай хуулийн шинчилсэн найруулгын төслийн 189-307 дугаар зүйлд Гаалийн бүрдүүлэлтийн горимын ангилал, төрөл, тэдгээрийг сонгох, барааг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах, гаалийн болон бусад татвар төлөх үүрэг үүсэх, гаалийн болон бусад татвар ногдуулах, тарифын бус хязгаарлалт, горимд байршуулахаас татгалзах, эрх шилжүүлэх, бараа, тээврийн хэрэгслийг буцаан гаргах, буцаан оруулах, гаалийн зөрчлийн улмаас горимын үйлчлэл дуусгавар болох, гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын кодтой холбогдсон харилцааг дахин хянаж, зарим зүйл, хэсэгт найруулгын өөрчлөлт оруулсан. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон г захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглосон тул гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түтгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг тодорхой тусгасан, гаалийн баталгаат агуулахад тавих нөхцөл, шаардлагыг тодорхойлсон. Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийг сонон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор зохицуулсан байсан боловч УИХ-аас 2023.01.06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт баталсан Гаалийн тухай хуульд нэмэл оруулах тухай хуулийг судалж үзэхэд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгохоор зохицуулсан. Гэвч 2023.01.06-ны өдөр батлагдсан Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд Гаалийн		
--	--	--	--	---	--	--

				тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 139.1.17.заалт нэмж, татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалтад оролцох тохиолдолд бүрдүүлэх бичиг баримтыг тогтоосон байна. Дээрх 2 хуульд зарчмын зөрүүтэй зохицуулалт орсон тул татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл олгох асуудлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор төсөлд найруулж, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн барихаар боловсруулсан болно. VI хэсэг.Гаалийн албаны тогтолцоо Гаалийн албаны тодорхойлолт, тогтолцоо, удирдлага, санхүүжилт, түүний үйл ажиллагааны зарчим, гаалийн байгууллага, түүний удирдлага, алба хаагчийн эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлсон. Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг “Санал шийдвэрлүүлэх тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн болно.		
1	Арга хэмжээ №1.1. ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн шаардлагатай журам зааврыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу, мөн түүнчлэн Монгол Улсын Сангийн яамны “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай” 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн №03/7707 албан бичгийн бичгийн хариу болгон хүргүүлэхээр тус тус Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан	01.01-12.08	100

	үндэслэн шаардлагат ай журам зааврыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгуулах арга хэмжээнд зохион байгуулахад оролцон			болгуулах арга хэмжээнд зохион байгуулахад оролцоно.	захиргааны хэм хэмжээний актад зохих ёсоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Тухайлбал, “Журам батлах тухай” ГЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн №А/25 тушаалаар “Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам”-ыг баталжээ. Журмыг батлахдаа Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 3 дугаар зүйл /Барааг урьдчилан тодорхойлох/, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дэх хэсэг /Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана./, Гаалийн тухай хуулийн 271^{1.1.1} /гаалийн үйл ажиллагааг өдөр тутмын зохион байгуулалтын удирдлагаар хангах;/, 271^{1.1.2} /гаалийн хууль тогтоомжоор эрх олгосон бол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар батлах;/, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 23.2 дахь хэсэг/Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална./-ийг тус тус үндэслэсэн нь журмын агуулга, зарчимд нийцэж байна гэж үзэхээр байна. Бүтцийн хувьд Нийтлэг үндэслэл, Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлт, Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлсон шийдвэр гаргах, Ангиллын урьдчилсан шийдвэрийн хүчинтэй хугацаа, шийдвэрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт, Бусад зүйл гэсэн зургаан зүйлтэй, 36 хэсэгтэй, 13 заалттай.		
--	--	--	--	---	--	--	--

					Хяналт-шинжилгээ, үнэлгээ Журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг тус бүрээр хүснэгтлэн /хавсралт 1/ харьцуулж, давхардал, хийдэл, зөрчил, хоорондын уялдаанд дүгнэлт гаргах замаар хийв. Тухайлбал, 1.Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хүрээнд Журмын 1.1, 1.2 дэх хэсэг Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зохицуулалттай агуулга, зорилгын хувьд давхардсан, 4.1 дэх хэсэг ХХХ-ийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн зохицуулалттай агуулга, зорилгын хувьд давхардсан, 4.2 дахь хэсэг ХХХ-ийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн зохицуулалттай агуулга, зорилгын хувьд давхардсан, 4.3, 4.3.1, 4.3.2 дахь хэсэг ХХХ-ийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй агуулга, зорилго ижил байдлаар давхардсан, 4.4 дэх хэсэг ХХХ-ийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй агуулга, зорилго ижил байдлаар давхардсан байна. 2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн хүрээнд Журмын “Гурав” дугаар зүйлийн гарчиг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн гарчигтай агуулга зорилго ижил байдлаар давхардсан, 3.2 дахь хэсэг ГТГТТХ-ийн 24.2 дахь хэсгийг хэл зүйн хувьд хуулбарласан, мөн агуулга зорилго ижил байдлаар давхардсан, 3.3 дахь хэсэг ГТГТТХ-ийн 24.3 дахь хэсгийг хэл зүйн хувьд хуулбарласан, мөн агуулга		
--	--	--	--	--	---	--	--

				зорилго ижил байдлаар давхардсан, “Дөрөв” дүгээр зүйлийн гарчиг ГТГТТХ-ийн 25 дугаар зүйлийн гарчгийг хэл зүйн хувьд хуулбарласан, мөн агуулга зорилго ижил байдлаар давхардсан, 4.2 дахь хэсэг ГТГТТХ-ийн 25.3 дахь хэсгийг хэл зүйн хувьд хуулбарласан, мөн агуулга зорилго ижил байдлаар давхардуулсан, 4.3.1 дэх заалт ГТГТТХ-ийн 25.2.1 дэх заалтыг хэл зүйн хувьд хуулбарласан, мөн агуулга зорилго ижил байдлаар давхардуулсан, 4.3.2 дахь заалт ГТГТТХ-ийн 25.2.2 дахь заалтыг хэл зүйн хувьд хуулбарласан, мөн агуулга, зорилго ижил байдлаар давхардуулсан байна. Мөн түүнчлэн журмын “Тав” дугаар зүйл /Гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт/, “Зургаа” дугаар зүйл /Бусад зүйл/ зохицуулалт нь тус тус Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “ЗУРГАДУГААР БҮЛЭГ” дугаар бүлэг/Барааны ангилал/-т заасан 22 дугаар зүйл /Барааг ангилах/ 24 дүгээр зүйл /Барааны ангиллыг урьдчилан тодорхойлуулах тухай хүсэлт гаргах/ 23 дугаар зүйл /Барааны ангиллыг урьдчилан тодорхойлох/, 25 дугаар зүйл /Барааны ангиллыг урьдчилан тодорхойлох шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, түдгэлзүүлэх/ зохицуулалтуудад агуулгын хувьд шууд хамаарахгүй зохицуулалт тусгасан байна. 3.Гаалийн тухай хуулийн хүрээнд Гаалийн тухай хуульд ангиллын кодыг урьчилан тодорхойлох зохицуулалт тусгагдаагүй бөгөөд тус хуулийн Нэгдүгээр дэд бүлэг/Гаалийн хяналтыг хэрэгжүүлэх үед хийх магадлан шинжилгээ/-ийн 252 дугаар зүйл/Гаалийн хяналт хийхэд шинжээч томилох/-ийн 252.1 дэх хэсэгт “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа,		
--	--	--	--	--	--	--

				тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээ хийнэ.” гэж заасан байна. Дүгнэлт, санал Журам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний өмчлөх эрх болон бусад эрх, Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг тус тус зөрчилдөөгүй, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хориглосон болон ямар нэгэн байдлаар хөндсөн зохицуулалт ямар нэгэн байдлаар тусгагдаагүй байна. Журмын нийт 36 хэсгээс 23 зүйл, хэсэг нь эрх зүйн зохицуулалтын хувьд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Гаалийн тариф, гаалийн татвар тухай хуулийн холбогдсон зохицуулалтаас хэл зүйн хувьд хуулбарласан, мөн агуулга зорилго ижил байдлаар давхардсан, агуулгын хувьд шууд хамааралгүй зохицуулалт тусгасан байна. Иймд “Журам батлах тухай” ГЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн №А/25 тушаалаар батлагдсан “Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам”-ын 1, 2 дугаар хавсралтыг Хяналтын нийтлэг журамд тусгаж, бусад хэсгийг бүхэлд нь хүчингүй болгож, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлээс хасуулах саналтай байна. БАРААНЫ АНГИЛЛЫН КОДЫГ		
--	--	--	--	--	--	--

					УРЬДЧИЛАН ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ Нэг.Нийтлэг үндэслэл 1.1.Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн байгууллага мэдүүлэгчийн хүсэлтээр барааг улсын хилээр оруулахаас өмнө барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлсон шийдвэр гаргах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, уг шийдвэр бүхий бараанд гаалийн бүрдүүлэлт хийх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино. 1.2."Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлсон шийдвэр" гэдэгт гаалийн байгууллагаас мэдүүлэгчид түүний хүсэлтэд дурдсан барааны ангиллын кодыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт"-ын дагуу тодорхойлон гаргаж өгөх шийдвэрийг хэлнэ. XXX. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Хоёр.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлт 2.1.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлт (цаашид хүсэлт гэх) гаргахад тухайн бараа нь дараах шаардлагыг хангасан байна. 2.1.1.импортын бараа нь илгээгч улсын нутаг дэвсгэрээс ачигдсан, ачигдахаар төлөвлөгдсөн, Монгол Улсын хилээр ороогүй байх,		
--	--	--	--	--	--	--	--

				2.1.2 мэдүүлэгчийн гаргаж өгсөн мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааны ангиллын кодыг тодорхойлох боломжтой байх. 2.1.3.гадаад худалдааны гэрээний дагуу нэг илгээгчээс ирүүлэх, барааны гарал үүслийн улс, үйлдвэрлэгч компани нэг байх, барааны нэр. зориулалт, марк, модель өөрчлөгдөхгүй байх. 2.2.Мэдүүлэгч хүсэлтийг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу гаалийн удирдах төв байгууллагад хандан шуудангийн "14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. Их тойруу 81/1 хаягаар бичгээр эсвэл цахимаар гаргаж болно. 2.3.Мэдүүлэгч хүсэлт гаргахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягтыг дараах байдлаар нөхөн бичнэ 2.3.1."Мэдүүлэгчийн мэдээлэл" хэсэгт мэдүүлэгч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, байгууллагын байршлын хаяг, шуудангийн хаяг, цахим шуудан, холбогдох утасны дугаар, хувь хүн бол овог нэр, регистрийн дугаар, байршлын хаяг, шуудангийн хаяг, цахим шуудан, холбогдох утасны дугаарыг тус тус бичнэ. 2.3.2."Барааны нэр" хэсэгт барааны ерөнхий нэр, худалдааны нэр, бараанд үйлдвэрлэгчээс оноосон нэр, гадаад нэршил зэрэг мэдээллийг бичнэ. 2.3.3."Барааны тодорхойлолт, дэлгэрэнгүй мэдээлэл" хэсэгт тухайн барааны төрөл зүйл, онцлог		
--	--	--	--	---	--	--

				шинж чанараас хамааран барааны марк, модель, артикул, зориулалт, материал, найрлага, бүрдүүлэгч хэсэг, барааны техникийн тодорхойлолт (ажиллах зарчим, гүйцэтгэх үйлдэл, техникийн үзүүлэлт), савлалт, баглаа боодлын тодорхойлолт, барааны гарал үүслийн улс, үйлдвэрлэгчийн нэр, байршил, хэрэглэгдэх салбар зэрэг мэдээллийг бичнэ. 2.3.4.Мэдүүлэгч нь барааны импортын төлөвлөлтийг хүсэлтэд бичнэ. Үүнд бараа импортлохоор төлөвлөсөн ойролцоо хугацаа, огноо, мэдүүлэх гаалийн байгууллага, боомт, нийт тоо хэмжээ, үнэ зэрэг мэдээлэл багтана. 2.4.Мэдүүлэгч нь тухайн барааны талаар гаргаж өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлохын тулд дараах бичиг баримт, материалыг хүсэлтэд хавсаргана: 2.4.1.барааны загвар, дээж, гэрэл зураг, бүдүүвч зураг, эсвэл схем зураг, 2.4.2.гадаад худалдааны бичиг баримт (гадаад худалдааны гэрээ, үнийн нэхэмжлэл, тээврийн бичиг баримт болон дагалдах бусад бичиг баримт); 2.4.3.техникийн бичиг баримт (барааны ангиллыг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл агуулсан техникийн паспорт, сертификат, каталог); 2.4.4.шаардлагатай бусад бичиг баримт. 2.5.Мэдүүлэгч барааны ангиллын талаар саналтай бол өөрийн тодорхойлсон барааны ангиллын кодыг бичнэ.		
--	--	--	--	---	--	--

					2.6.Мэдүүлэгч гаалийн удирдах төв байгууллагаас гаргасан шийдвэрийг бүрэн, эсвэл хэсэгчлэн нийтэлж болох эсэхийг зөвшөөрч тэмдэглэнэ. 2.7.Хуулийн этгээдээс гаргасан хүсэлтэд хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулна. Харин хувь хүнээс гаргасан хүсэлтэд тухайн иргэн өөрөө гарын үсэг зурна. Гурав.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлсон шийдвэр гаргах 3.1.Гаалийн удирдах төв байгууллага мэдүүлэгчээс гаргаж өгсөн хүсэлт. барааны мэдээлэл, хавсаргасан бичиг баримт, материалд заасан барааны ангиллын урьдчилсан шийдвэрийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бичгээр гаргана.		
					3.2.Мэдүүлэгчээс ирүүлсэн бичиг баримт хангалтгүй тохиолдолд гаалийн байгууллага тэдгээрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор нэмэлт материал, мэдээлэл ирүүлэх тухай мэдүүлэгчид мэдэгдэнэ. ГТГТТХ.24.2		
					3.3.Мэдүүлэгч гаалийн удирдах төв байгууллагаас нэмэлт бичиг баримт, мэдээлэл гаргаж өгөх тухай мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гаргаж өгнө. ГТГТТХ.24.3		
					3.4.Барааны ангиллын урьдчилсан шийдвэрийг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн		

				Жагсаалт, Ерөнхий тайлбар дүрэм, Тайлбар бичиг, Дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан зөвлөмж, шийдвэр болон үндэсний хууль тогтоомж, эрхзүйн актыг үндэслэл болгон 8 оронтой кодын түвшинд гаргана. 3.5.Гаалийн байгууллага ангиллын урьдчилсан шийдвэрийг мэдүүлэгчээс гаргасан хүсэлт, шаардлага хангасан бичиг баримт, материалыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан гаргана. 3.6.Ангиллын урьдчилсан шийдвэрийг гаалийн удирдах төв байгууллагад барааны ангиллын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдах албан тушаалтан, түүний эзгүйд тухайн нэгжийг харьяалан удирдах албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна. 3.7.Ангиллын урьдчилсан шийдвэрийг хоёр үндсэн хувь үйлдэх бөгөөд нэг хувийг мэдүүлэгч, үлдсэн нэг хувийг гаалийн байгууллага хадгална. 3.8.Мэдүүлэгч нэмэлт бичиг баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй тохиолдолд гаалийн байгууллага ангиллын урьдчилсан шийдвэр гаргахаас татгалзана. 3.9.Эрх бүхий байгууллагаас эрх зүйн баримт бичгийн төсөлд барааны ангиллын кодын талаар санал авахаар хүсэлт ирүүлэх тохиолдолд энэ журмын 2.4.1, 2.4.3-т зааснаас бусад бичиг баримтыг шаардахгүй бөгөөд барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлж албан бичгээр хүргүүлнэ.		
--	--	--	--	--	--	--

					Дерев.Ангиллын урьдчилсан шийдвэрийн хүчинтэй хугацаа, шийдвэрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох		
					4.1.Барааны ангиллын урьдчилсан шийдвэрийн хүчинтэй хугацаа нь уг шийдвэрийг гаргасан өдрөөс эхлэн 3 жил байна. XXX. 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг		
					4.2.Мэдүүлэгчийн ирүүлсэн баримт, мэдээлэл нь буруу, хуурамч болох нь шийдвэр гаргасны дараа тогтоогдсон эсвэл буруу, хуурамч байж болох баримт, сэжиг байгаа бол гаалийн удирдах төв байгууллага ангиллын урьдчилан тодорхойлсон шийдвэрийг түдгэлзүүлнэ. XXX. 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг ГТГТТХ-ийн 25.3 дахь хэсэгтэй давхардсан		
					4.3.Ангиллын урьдчилсан шийдвэрийг дараах үндэслэлээр хүчингүйд тооцно 4.3.1.гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, үндэсний кодоод өөрчлөлт оруулсан нь шийдвэрт заасан барааны ангилалд нөлөөлөхөөр бол. ГТГТТХ-ийн 25.2.1 дэх заалттай давхардсан 4.3.2.шинээр байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан. ГТГТТХ-ийн 25.2.2 дахь заалттай давхардсан 4.4.Гаалийн удирдах төв байгууллагаас ангиллын урьдчилсан шийдвэр гаргахаас татгалзсан, шийдвэрийг		

				түдгэлзүүлсэн, эсвэл хүчингүй болгосон бол мэдүүлэгчид холбогдох үндэслэлийг бичгээр мэдэгдэнэ. XXX. 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг 4.5.Мэдэгдэхдээ Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасныг мөрдлөг болгох бөгөөд энэ журмын 4.6-д заасан хүсэлт гаргах талаар мэдэгдэлд заана. 4.6.Ангиллын урьдчилсан шийдвэрийг энэ журмын 4.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол мэдүүлэгч дахин хүсэлт гаргаж, ангиллын урьдчилсан шийдвэр гаргуулж болно. Тав. Гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт 5.1.Ангиллын урьдчилсан шийдвэрийг харьяа гаалийн газар, хороод дагаж мөрдөнө. 5.2.Мэдүүлэгч барааг гаалийн байгууллагад мэдүүлэхдээ гаалийн удирдах төв байгууллагын даргын баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг нөхөн бичих заавар"-ыг мөрдөж, барааны гаалийн мэдүүлгийн маягтын 23 дугаар хүснэгтэд ангиллын урьдчилсан шийдвэрт заасан барааны ангиллын кодыг нөхөн бичнэ 5.3.Мэдүүлэгч гаалийн удирдах төв байгууллагаас гаргасан ангиллын урьдчилсан шийдвэрийн эх хувийг хуулбарын хамт гаалийн байгууллагад гаргаж өгнө 5.4.Гаалийн байгууллага гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтыг хүлээн авч, ангиллын урьдчилсан шийдвэртэй тулган шалгана.		
--	--	--	--	---	--	--

					5.5.Хэрэв барааны мэдээлэл зөрүүтэй, үндэслэл бүхий баримт мэдээлэл, сэжиг байгаа бол гаалийн удирдах төв байгууллагын даргын баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын дагуу шийдвэрлэнэ. 5.6.Харьяа гаалийн газар, хороо нь барааны ангиллын урьдчилсан шийдвэр зөрүүтэй болохыг тогтоож шийдвэрлэсэн бол энэ тухай гаалийн удирдах төв байгууллагад мэдэгдэнэ. 5.7.Ангиллын урьдчилсан шийдвэр гарахаас өмнө бараа нь улсын хилээр орж ирвэл мэдүүлэгч бараагаа мэдүүлж гаалийн бүрдүүлэлт хийнэ. Зургаа.Бусад зүйл 6.1.Ангиллын урьдчилсан шийдвэр нь зөвхөн хүсэлт гаргасан этгээдэд хамаарна. 6.2.Гаалийн удирдах төв байгууллагын барааны ангиллын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гүйцэтгэх албан тушаалтан ангиллын урьдчилсан шийдвэрийг гаалийн бүрдүүлэлтийн цахим сүлжээнд байршуулна. 6.3.Гаалийн удирдах төв байгууллага мэдүүлэгчийн зөвшөөрлийг үндэслэн ангиллын урьдчилсан шийдвэрийг бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар гаалийн байгууллагын цахим хуудсанд байршуулж болно.		
--	--	--	--	--	--	--	--

					6.4.Гаалийн байгууллагад мэдүүлсэн барааны гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримт болон бараа нь ангиллын урьдчилсан шийдвэрээс зөрсөн тохиолдолд мэдүүлэгч холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ. 6.5.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах, гомдлыг хянан шийдвэрлэх асуудлыг холбогдох хуульд заасны дагуу зохицуулна.		
	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	ГЕГ-аас батлан гаргах захиргааны хэм хэмжээний акт, захиргааны актын төслийн хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, санал өгсөн байх	Тайлант хугацаанд ГЕГ-аас батлан гаргах дараах захиргааны хэм хэмжээний актын төслийг хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, санал өгч ажилласан. Үүнд: 1.“Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага” 2.“Тээврийн хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн журам 3. “Барааны, сорьц, дээж, загвар авах магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай өөрчлөлттэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: 1.Журмын нэмэлт, өөрчлөлтийн төслийн хууль зүйн техникийг “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны №59 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д нийцүүлэн мөр хоорондын зай нэмэх, хэсгийн өмнө нэг, заалтын өмнө хоёр интер авах, мөр хооронд илүү зайг шахах зэрэг найруулгын засвар хийх. 2.Журмын нэмэлт, өөрчлөлтийн төсөл дэмжигдэн холбогдох шийдвэрээр батлагдсан тохиолдолд Хууль	01.01-12.08	100

					тогтоомжийн тухай хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээний актад заасны дагуу холбогдох баримтуудыг бүрдүүлж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэх шаардлагатай.		
2	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх	УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх ажилд хамтран арга зүйн зөвлөгөө өгч ажилласан болно. ГЕГ-т хамаарах ✚ УИХ-ын тогтоол - 4 ✚ Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж - 1 ✚ Засгийн газрын тогтоол - 16 ✚ Засгийн газрын хуралдааны тэмдэглэл - 10 ✚ Засгийн газрын албан даалгавар - 2 буюу нийт 33 тогтоол шийдвэрийн биелэлт.	01.01-06.05	100
3	Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Захиргааны, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Гаалийн Ерөнхий Газрын даргын олгосон итгэмжлэлийн	Гаалийн ерөнхий газарт холбогдуулан гаргасан захиргааны 2 хэрэгт ГЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримт, тайлбар гаргах, шүүх хуралдаанд мэтгэлцэн оролцох, гомдол гаргах зэргээр ажилласан. Үүнд: УХШИГГ-ын ЗА-ны дарга Б.Ганбатын 2023.09.15-ны өдөр СБДИХАШШүүхэд "2021.10.09-2022.09.15-ны өдөр	01.01-12.08	100

	ажилласан байдал			үндсэн дээр нэхэмжлэгч, хариуцагч, иргэний хохирогчоор оролцсон талаар, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын шийдвэр, хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хамтран ажилласан байна.	хүртэл ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх хэмжээний олговор 13,444,179 /Арван гурван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга нэг зуун ес/ төгрөг гаргуулах энэ хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийхийг хариуцагчид даалгах" хэргийг СБД-ийн ИХАШШүүхийн 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 181/ШШ2023/000011 дүгээр шийдвэрээр 430,171 мянган төгрөгийн хэрэгсэхгүй болгож бусад хэсгийг хангаж шийдвэрлэсэн. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023.02.13-ны өдрийн 373 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын гомдол гаргасан. Харин “Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзах тухай” 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн №001/ШХТ2024/00754 Улсын дээд шүүхийн Иргэнийн хэргийн нийт шүүгчдийн хуралдааны Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн шүүгч М.Батзоригийн Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан Нотлох баримтад хийсэн үзлэгт Статистикийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баясгалан, Хуулийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Э.Ганболд, Үйлчилгээ, аж ахуйн албаны архивын ажилтан Г.Баасансүрэн нар оролцов. Үзлэгээр шүүгчийн шаардсаны дагуу “Ган-Илч” ХХК-ийн гаалийн мэдүүлэг, хавсралт баримтуудыг Сайншанд дахь гаалдийн газраас шуурхай гаргуулан авч, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу “Хуулбар үнэн” тэмдэгээр нотлох баримтын шаардлага ханган 19 хуудас материал өгсөн болно. Жич: Үүний өмнө нэхэмжлэгч талаас энэхүү нотлох баримтыг гаргуулан авахаар Сайншанд дахь гаалийн газар		
--	------------------	--	--	--	--	--	--

					хүсэлт гаргахад энэ баримт тус гаалийн газрын архивт байхгүй тухай хариу албан бичиг өгч байсан байна.		
4	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтэр		Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	Тайлант хугацаанд Хуулийн хэлтсийн чиг үүрэгт хамааралтай бодлогын баримт бичгүүд байгаагүй болно.	01.01-12.08	100
5	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтэр		Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар тайлагнана.	1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: - Зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-962.5 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/131 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.04.15-ны өдөр нээлттэй зарлан 2024.05.07-ны өдөр нээхэд Масс теч ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан. - Цацрагийн хяналтын төхөөрөмж шилжүүлэн суулгах засвар /Алтанбулаг, Боршоо/-306.0 сая төгрөг Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/202 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендер амжилтгүй болсон тул Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.06-ны өдөр дахин нээлттэй зарлаж, 2024.05.27-ны өдөр нээхэд Масс Теч ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан.	01.01-12.08	100

6	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэх ажилд оролцсон байна.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор ХЗДХЯ, Монголын цахим институт, Монгол улсын MNS ISO 31010:2016 стандарт, ҮТХороо зэрэг төрийн байгууллагын Байгууллагын эсдэлийг тодорхойлсон эрх зүйн баримт бичгийг судлаж тус нэгжийн дотоод эрсдэлийг ангилан, тогтоосон болно. Үүнд: 1. Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгууллалтын эрсдэл, 2. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл, 3. Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл, 4. Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл,	01.01-12.08	100
7	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар	-	1.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүний мэдээллийг тухай бүр түгээсэн байна. 2.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэн ажиллана.	НЭГ.Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн ахлагч Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Захиргааны хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн дагуу дараах танилцуулга, судалгааг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн Хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн зарим ажлын танилцуулга. 3 хуудас. 2.Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хэм хэмжээ тогтоосон, Нийтээр дагаж мөрдөх шинжтэй эрх зүйн актын жагсаалт, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болон Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байдал /Судалгаа/ 12 хуудас. 3.Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны хэм хэмжээний актын судалгаа 22 хуудас. 3.Гаалийн ерөнхий газрын даргад Гаалийн тухай хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгаа. 7 хуудас	01.01-12.08	100

					ХОЁР.Тагнуулын байгууллагын ирүүлсэн Албан шаардлагын хүрээнд Гаалийн ерөнхий газраас байгуулсан “Ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны №1, №2 тушаалаар байгуулсан ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж хуралд танилцуулга бэлтгэх, “Гаалийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ын төсөл боловсруулах, хурлын тэмдэглэл хөтлөх, холбогдох байгууллагаас санал авах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж илүү цагаар ажилласан. “Гаалийн албаны нууцын жагсаалт-Гаалийн улсын байцаагчийн үүрэг” сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 09.00-09.55 цагт “Мэдээллийн цаг”-аар төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, Гаалийн тухай хуулийн 5.2 дахь заалтыг хэрэгжүүлэх арга зүй, Албаны нууцын жагсаалтад хамаарах мэдээллийн ашиглалт, хамгаалалтын асуудлын талаар Гаалийн ерөнхий газрын албан хаагчдад зорилсан сургалтын материал танилцуулга бэлтгэв. Үүний дагуу 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 09.00-09.55 цагт “Мэдээллийн цаг”-аар Хуулийн хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Ч.Тамираа дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. “Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам” сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10.00-11.00 цагт харьяа гаалийн газар, хорооны захиргаа, хүний нөөц хариуцсан албан хаагчдад Захиргааны ерөнхий хуулийн хувийн хэрэг хөтлөх, сонсох ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтын талаарх арга зүйн сургалтыг зохион байгуулж, дэлгэрэнгүй мэдээлэл өгч, оролцогчдын тулгамдсан асуултад зөвлөгөө өгч, харилцан ярилцлага зохион байгуулав. Тайлангийн хугацаанд нийт 77 албан бичиг ирсэн ба үүнээс хариугүй 35, хариутай 42 албан бичгээс 42-т нь бичгээр хариу өгч шийдвэрлэж ажилласан. 52 албан бичиг явсан ба Захиргааны хэргийн шүүх, Нийслэлийн прокурорын газар зэрэг төрийн		
--	--	--	--	--	---	--	--

					байгууллагууд -33, харьяа гаалийн газар хороонд -10, иргэн, аж ахуйн нэгжид -4 албан бичиг явуулсан байна. Хугацаа хэтэрсэн, хариу өгөөгүй албан бичиг байхгүй болно.																																																		
8	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжруулж ажиллаж, үр дүнг тайлагнана.	Гаалийн улсын байцаагч Э.Ганболд нь 2024 онд Ээлжийн амралт 24 өдөр эдэлсэн, бүрэн ажилласан болно.	01.01-12.08	100																																																
9	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах төслийг боловсруулсан. Үүнд: “Гаалийн улсын байцаагчид мөнгөн тэтгэмж олгох журам”-ын төсөл	01.01-12.08	100																																																
10	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах	Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянасан, хэрэгжилтийг хангасан байх - Тайланд нотломжийг хавсаргасан байх	-	Харьяалагдах нэгж, харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдлага, арга зүйгээр хангана.	Харьяалагдах нэгж, харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах ажилд оролцсон болно.Үүнд: <table><tr><td>№</td><td>Харьяалах нэгж</td><td>А</td><td>Б</td></tr><tr><td>1</td><td>УБГГ</td><td>6</td><td>27</td></tr><tr><td>2</td><td>ЗҮГГ</td><td>20</td><td>64</td></tr><tr><td>3</td><td>ЧХОУНБГГ</td><td>23</td><td>41</td></tr><tr><td>4</td><td>Сэлэнгэ аймаг дахь ГГ</td><td>17</td><td>34</td></tr><tr><td>5</td><td>Гашуунсухайт дахь ГГ</td><td>14</td><td>31</td></tr><tr><td>6</td><td>Дорнод аймаг дахь ГГ</td><td>12</td><td>21</td></tr><tr><td>7</td><td>Шивээхүрэн дэх ГГ</td><td>6</td><td>31</td></tr><tr><td>8</td><td>УХШИГГ</td><td>11</td><td>5</td></tr><tr><td>9</td><td>Орхон аймаг дахь ГГ</td><td>8</td><td>13</td></tr><tr><td>10</td><td>Ховд аймгийн Булган дахь ГГ</td><td>1</td><td>12</td></tr><tr><td>11</td><td>Баян-Өлгий аймаг дахь ГГ</td><td>22</td><td>26</td></tr></table>	№	Харьяалах нэгж	А	Б	1	УБГГ	6	27	2	ЗҮГГ	20	64	3	ЧХОУНБГГ	23	41	4	Сэлэнгэ аймаг дахь ГГ	17	34	5	Гашуунсухайт дахь ГГ	14	31	6	Дорнод аймаг дахь ГГ	12	21	7	Шивээхүрэн дэх ГГ	6	31	8	УХШИГГ	11	5	9	Орхон аймаг дахь ГГ	8	13	10	Ховд аймгийн Булган дахь ГГ	1	12	11	Баян-Өлгий аймаг дахь ГГ	22	26	01.01-12.08	100
№	Харьяалах нэгж	А	Б																																																				
1	УБГГ	6	27																																																				
2	ЗҮГГ	20	64																																																				
3	ЧХОУНБГГ	23	41																																																				
4	Сэлэнгэ аймаг дахь ГГ	17	34																																																				
5	Гашуунсухайт дахь ГГ	14	31																																																				
6	Дорнод аймаг дахь ГГ	12	21																																																				
7	Шивээхүрэн дэх ГГ	6	31																																																				
8	УХШИГГ	11	5																																																				
9	Орхон аймаг дахь ГГ	8	13																																																				
10	Ховд аймгийн Булган дахь ГГ	1	12																																																				
11	Баян-Өлгий аймаг дахь ГГ	22	26																																																				

					12	Увс аймаг дахь ГГ	7	22		
					13	Сайншанд дахь ГГ	13	22		
					14	Дархан-Уул аймаг дахь ГГ	16	12		
					15	Сүхбаатар аймгийн Бичигт дэх ГГ	1	16		
					16	Говь-Алтай аймгийн Бургастай дахь ГХ	1	15		
					17	Хөвсгөл аймгийн Ханх дахь ГХ				
					18	Завхан аймгийн Арцсуурь дахь ГХ	2	8		
					19	Ханги дахь гаалийн газар	3	14		
					20	Нийт	183	414		
11	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байх; -Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Хүчин төгөлдөр бус болгосон дүрэм, журамд хяналт шинжилгээ э, үнэлгээ хийсэн байх; -Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	-	1.Мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	1 АТГ-ын ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/4936 дугаартай “Журам хянасан тухай” албан бичгийн дагуу ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан төсөл боловсруулж, Гаалийн байгууллагын https://customs.gov.mn цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 30 өдрийн хооронд байрлуулан, 2024.05.06-ны өдрийн онлайн хурлын үер үүрэг өгч харьяа гаалийн газар хороодоос албан бичгээр, ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас дотоод зурвасаар санал авч нэгтгэн ажиллав. Нийт 17 нэгжээс 46 санал ирсний 20 саналын утга, агуулга давхцсан бөгөөд 26 саналыг уг журмын төсөлд тусган батлуулахаар хүлээгдэж байна.				01.01-12.08	100

	үйл ажиллагаа ндаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруул ах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах						
--	---	--	--	--	--	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7

1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	1.2024.05.24-ний өдрийн 09.00-12.00 цагт Удирдлагын академийн "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны хуулийн төсөл" хэлэлцүүлэгт хамрагдав. 2.Сангийн яаманд "Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад хэрэгжүүлэх жендэрийн стратегийн үнэлгээ"-ний талаарх сургалтад 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр оролцсон. 3.Гаалийн ерөнхий газарт 2024.11.08-ны өдөр Ёс зүй, авлигын чиглэлээр Дэлхийн Гаалийн байгууллагын чиг хандлагыг үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй харьцуулан, өнөөгийн практикт хэрхэн хэрэгжүүлэх онол, практикийн мэдлэг эзэмшүүлэхэд сургалтын зорилготой "Ёс зүйн чиг хандлагыг төлөвшүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалтад оролцсон.	01.01-12.08	100
2	Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Чрймаа багшийн гаргасан хичээлийг бие даан судалсан байх	"Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх" зорилтын хүрээнд Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх зорилтын хүрээнд анхан шатны мэдлэг эзэмшсэн	01.01-12.08	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛИЙН ХЭЛСТИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ



/Э.Ганболд/

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Э. ГАНБОЛДЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хуулийн хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”					
1.	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал	60	10 -4	70	65
2.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	60	10 -5	70	60
3.	Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал	60	10	70	67
4.	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	60	10	70	55
5.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	60	10 -3	70	67
6.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	60
7.	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	60	10	70	67
8.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	67
9.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	60	10	70	65
10.	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах	60	10	70	60
11.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон	60	10	70	50

тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах				
Дундаж оноо:			70.0	62,8

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	14	14	10
2.	2025 оноос хос бичгээр албан хэрэгтэй хөтлөхтэй хрорглуулан Монгол бичиг бие даан сурах	14	14	10
Дундаж оноо:			14	10

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Асуудал шийдвэрлэх	7	7
3.	Хариуцлагатай байдал	7	7
4.	Дүн шинжилгээ хийх	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Дундаж оноо:		7	7

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

№	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

№	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар(арга хэмжээ)-ын биелэлт орно)	70 52
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	8

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	87,8
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		99

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Хуулийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

..... (Ч.Тамираа)
2024.12.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Гаалийн улсын байцаагч

..... (Э.Ганболд)
..... (огноо)

Үнэлгээг хянасан:


Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

..... (Г.Энхтайван)
2024.12.20 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн
улсын ахлах байцаагч



..... (Ө.Тэгшээ)
2024.12.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

Гаалийн ерөнхий газрын дарга

..... (Р.Отгонжаргал)
..... (огноо)